

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ

ДЭЛХИЙН ШИНЭ ДЭГ ЖУРАМД ЗҮҮН ХОЙТ АЗИЙН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Ц. Баатар

1992 оны долоодугаар сарын 29-31-нд Улаанбаатар хотноо "Дэлхийн шинэ дэг журамд Зүүн хойт Азийн эзлэх байр суурь" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болов. Бага хуралд бүс чутгийн Монгол улс, ОХУ, БНХАУ, АНУ, Япон, БНСУ, ЗНАСАУ-ын төлөөлөгч 50 шахам эрдэмтэн, улс төрч-дипломатч оролцов. Зүүн хойт Азийн өнөөгийн байдал хэтийн төлөв, ЗХА-ийн үс нутгийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааг ергэтгөн хөгжүүлэх арга зам, ЗХА-ийн бүс нутагт энх тайван ажлгүй байдлыг хангах, Монгол улс, ЗХА-ийн орнуудтай тогтоосон харилцааны өнөөгийн байдал, хэтийн төлөв гэсэн 4 асуудлын хүрээнд 10 гаруй нэлтгэлийг бага хурал сонсов.

Бага хурлыг зохион байгуулагч нь Монгол улсын ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төв, Гадаад харилцааны яам, БНСУ-ын Хөнхжин их сургуулийн Ази-Номхон далай судлалын төв юм. Улаанбаатарын бага хурал нь Монгол улс, Зүүн хойт азийн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааны асуудал хэлэлцсэн

Ц. Баатар-Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан

эрдэмтэн, мэргэжилтний олон улсын уулзалт, бага хурлын 3 дахь нь бөгөөд түрүүчийн хоёр хурал 1990 оны арав, 1991 оны есдүгээр сард Улаанбаатар хотноо болсон билээ.

Өнөөдөр дэлхийн олон улс Зүүн хойт Ази /ЗХА/-ийг тусгайлан сонирхож, түүний одоогийн улс төр, эдийн засгийн байдал, хэтийн төлөвийг нарийвчлан судалж, дотоод, гадаад бодлогоддоо энэ бүгдийг харгалзан үздэг боллоо. Энэ талаар ОХУ, АНУ, БНХАУ, Умард, Өмнөд Солонгос, Япон зэрэг орон энцгөй анхаарал тавьж байна. Дээрх орнууд бүс нутгийн судалгааны төв, хүрээлэн байгуулж эрдэмтэн, мэргэжилтний уулзалт, эрдэм шинжилгээний олон улсын бага хурал байнга зохиож, судалгааны ажлын урьдчилсан үр дүнгээр харилцаа санал солилцох явдал тогтмолжив. Монгол улс ЗХА-ийн бүс нутгийн орнуудтай хоёр талын харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөх, түүгээр дамжин цаашид олон талын хамтын ажиллагаа эдийн засгийн интеграцийн үйлст оролцох явдалд их ач холбогдол өгч байна.

Манай улс энэ бүс нутагт өрнөж буй үйл явцад идэвхтэй оролцох, өөрийн байр суурийг илэрхийлэх үүднээс бүс нутгийн орнуудын эрдэмтэн, мэргэжилтний уулзалт, эрдэм шинжилгээний олон улсын бага хурлыг 1990 оноос эхлэн өөрийн оронд тогтмол хийлгэж ирлээ. Үүний гурав дахь нь 1992 оны 7 дугаар сарын 29-31-нд Улаанбаатар хотноо болсон "Дэлхийн шинэ дэг журамд Зүүн хойт Азийн эзлэх байр суурь" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал юм. Тус бага хуралд АНУ, БНХАУ, ОХУ, БНСУ, БНАСАУ, Монгол улс долоон орны 50 шахам эрдэмтэн, мэргэжилтэн, улс төрч-дипломат оролцлоо. Монгол улсын ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төв, Гадаад харилцааны яам, БНСУ-ын Хөвчийн их сургуулийн Ази - Номхон далай судлалын төв хамтран зохиосон тус бага хурлын гол зорилго нь ЗХА-ийн өнөөгийн байдал, цаашдын төлөвийг нухацтай ач хэлэлцэж санал солилцох, харилцаа ойлголцох, итгэлцлийг бэхжүүлж бүс нутгийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааг өрнүүлэхэд тус дөхөм болох явдал байв.

Бага хурал ЗХА-ийн өнөөгийн байдал хэтийн төлөв, - ЗХА-ийн бүс нутгийн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх арга зам, - ЗХА-ийн бүс нутагт энх тайван, аюулгүй байдлыг хангах, - Монгол улс, ЗХА-ийн орнуудтай тогтоосон харилцааны өнөөгийн байдал хэтийн төлөв гэсэн 4 асуудлын хүрээнд 10 гаруй эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцээний дотор дэлхий нийтийн хөгжлийн ерөнхий хандлага, Зүүн хойт Азийн улс түмний ирэх зуунд гүйцэтгэх үүрэг сэдвээр проф. Ч. Ен Сик /БНСУ/, бүс нутгийн хамтын ажиллагааны сэдвээр проф. Скалапино /АНУ/, проф. Като /Япон/, Монгол, бүс нутгийн орнуудын хамтын ажиллагаа сэдвээр проф. Ч. Далай, П. Лувсандорж /Монгол/, проф. Энхээ /БНХАУ/, Парк Ки-Ань /БНСУ/, бүс нутгийн аюулгүй байдлын сэдвээр проф. Смит /АНУ/, Болд /Монгол/ нар илтгэв.

Илтгэлүүдэд дэлхий нийтийн хөгжлийн ерөнхий хандлага бүсчлэх чиглэлтэй болж буй өнөө үед Өрнөд-Дорнод, Умарт-Өмнөт гэж хуваах үзэл баримтлал утгаа алдаж, манай гаригийн улс гүрнүүд ойрын ирээдүйд Европ, Америк, Ази гэсэн гураван том туйлд хуваагдаж болох тухай, дэлхийн эдийн засагт ЗХА-ийн бүс нутгийн гүйцэтгэх үүрэг роль, бүс нутгийн орнуудын харилцааны өнөөгийн байдал, цаашдын төлөв, итгэлцлийг бэхжүүлэх, эдийн засгийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж зэрэг олон чухал асуудлыг тал бүрээс нь нухацтай ач үзэв. Дээрх асуудлаар санал солилцох явцад тухайн асуудалд хандах эрдэмтдийн санаа бодол өөр өөрөөр илэрхийлэгдэж байсан бөгөөд тэр бүхийг жигдрүүлж нэгэн мөр болгож, нэгдсэн үзэл баримтлал боловсруулан гаргах зорилт тавигдаагүй, эрдэмтэн бүхэн бусдын санаа бодол, түүний үндэслэлтэй тодорхой танилцаад тус бүрдээ өөрийн хувийн дүгнэлт хийж байв.

Бага хуралд тавьсан илтгэлүүдэд ЗХА-ийн бүс нутгийн харилцаа,

хамтын ажиллагаанд Монгол улсын эзлэх байр суурь, түүний өнөөгийн байдал хэтийн төлөвийн талаар олон эрдэмтэн илтгэл тавьж, санал бодлоо илэн далангүй солилцож, чөлөөтэй маргаан явуулж байлаа. Энэ удаагийн хурлын нэг онцлог тал мухам үүнд оршино. Тийм ч учраас энэхүү мэдээлэлд бага хурал дээр илэрхийлэгдсэн олон санал бодол, үндэслэлүүдээс Монгол улс бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох асуудалтай холбогдох зарим санаа, үндэслэлийг товч хөндөв.

ЗХА-ийн бүс нутаг харилцан хамаарал нхтэй, эдийн засгийг хөгжүүлэх нэн их нөөц баялагтай, хамтын ажиллагаа тогтоох давуу талын нөхцөл боломж аргаантай юм. Өөрөөр хэлбэл тус бүс нутгийн улс орон бүр харилцан нэг нэгийгээ сэлбэн нөхөх давуулаг онцлогуудтай. Тухайлбал, Япон, Өмнөд Солонгос технологиороо, Америк хөрөнгө капиталараа, ОХУ, Монгол түүхий эдээрээ, БНХАУ, БНАСАУ хүн хүчээрээ тулхүү оролцож хамтран ажиллах өргөн боломж байна гэж проф. Ч. Далай тэмдэглэв.

Монгол улс ЗХА-ийн орнуудтай эдийн засгийн салбарт хамтын ажиллагаагаа өргөтгөхийн тулд юуны урьд төр засаг-шинжлэх ухаан-худалдааны байгууллагын гурван талын хүмүүс оролцсон зохицуулах зөвлөл байгуулах, одоогийн хоёр талын хамтын ажиллагааны хүрээг цаашид өргөтгөж олон талын хамтын ажиллагааны хэлбэрт оруулахыг идэвхтэй чармайх, хятад, орос, монгол гурван орны оролцоотойгоор "Түмэн голын" төслөөс дутуугүй олон талын ач холбогдолтой төмөр зам төсөл боловсруулж хэрэгжүүлэх цаг болжээ. Иймд энэ чиглэлээр хамтарсан судалгаа ойрын үед явуулах хэрэгтэй гэсэн саналыг проф. Энхээ тавив.

Монгол улс түргэн хөгжих эдийн засгийн угтвар нөхцөлтэй. Энэ нь нэгд, илүүдэл үйлдвэрлэл явагдсан байх, хоёрт, тэрхүү илүүдлийг хуримтлуулах ёстой, гуравт, илүүдлийг эргэлтэнд оруулах хэрэгтэй, дөрөвт, хөрөнгө оруулалт нь их төлөв үйлдвэрлэлийн салбарт хийгдсэн байх шаардлагатай гэж проф. П. Лувсандорж үзэж байна.

Хятад, Монгол, Орос гурван улсын хамтын ажиллагааны объект газар бол Монголын Дорнод аймаг юм. Ийм учраас Дорнод монголын хөгжлийг хурдасгах стратегийн хөтөлбөр боловсруулж энэ ажлыг ойрын хугацаанд хэрэгжүүлэх талаас нь бодолцох ёстой. Европ Азийг холбосон аято зам, төмөр зам тавих боломжтой. Монголыг "Түмэн голын" төсөлтэй, цаашлаад ЗХА-ийн бүс нутагтай холбох асар их ирээдүйтэй онцгой ач холбогдолтой "гүүр" чухамдаа энэ л юм гэж проф. Жан Да Минь үзэж байна.

Монголын тал хөрөнгө оруулалтын болоод бусад хууль эрхийн актаг эргэн харах юм бол Солонгосын корпорациуд бизнесменүүд Монголд хөрөнгө оруулах асар их сонирхолтой байна. Тэд байгалийн баялгийг хамтран ашиглах, үйлдвэр, технологи оруулах, шинэ техник технологиор үйлдвэрийн зарим дамжлагыг тоноглох хамтран ашиглах, маркетингийн хамтын ажиллагааг өргөтгөж, улмаар дэлхийн зах зээлд хамтарч гарах зэрэг олон асуудлаар харилцан ашигтай хамтран ажиллах өргөн боломжтой болохыг проф. Парк-Ки-Ань тэмдэглээд хамтын ажиллагааг цаашид өргөтгөн хөгжүүлэх арга замын талаар тодорхой санал дэвшүүлэв.

ЗХА-ийн бүс нутгийн орнуудын эрдэмтэд, мэргэжилтний байнгын уулзалт, бага хурлын улс төрийн ач холбогдол нь Монголын эрдэмтэд бүс нутгийн орнуудын энэ чиглэлийн нэрт эрдэмтэдтэй учирч, ажил төрлийн кэлхээ холбоо тогтоон, харилцан ойлголцож, ном хаялцаж, санал бодлоо хуваалцаж, тэдний судалгааны ажлын үр дүн, шинэ мэдээ материалтай танилцаж, мэдээлэл солилцож байгаад оршино.

Бага хурлаас дэвшүүлсэн шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлт, саналууд нь Монгол-Зүүн хойт Азийн бүс нутгийн орнуудын харилцаа хамтын ажиллагааны хэтийн төлөвийг боловсруулахад зохих үндэслэл болох нь дамжиггүй.